



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/182

Сүхбаатар сум

Дэмжлэг үзүүпэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", 29.1.6 "г", Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Монгол Улсад Атар газар эзэмшсэний 60 жилийн ой, Шаамар суман дахь Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвийн 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд газар тариалангийн түүхэн уламжлалыг дэлгэрүүлэх зорилгсор эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

3. Дэмжлэгийн 1.705.000 /нэг сая долоон зуун таван мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.

4. Зардлын тайланг 2019 оны 06 дугаар сарын 15-ны дотор тайлагнахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Энхбат/-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

My Doc Zahiramj